

Golomt Capital®

# Хөрөнгийн зах зээлийн ТОЙМ

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.04.18

Олон улсын  
хөрөнгийн зах зээл

Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

Онцлох индексүүдийн өөрчлөлт


Дэлхийн томоохон индексүүдийг бүс нутгаар нь ангилан 7 хоног, сар, жилийн ханшийн өөрчлөлтүүдийг үзүүлэв. Үүнд АНУ-ын Dow Jones, S&P 500, Nasdaq, Германы Dax, Английн FTSE 100, БНХАУ-ын CSI 300, Хонг-Конгийн Hang Seng, Японы Nikkei 225 индексүүд багтана.

Америкийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dow Jones	\$34,451.23	\$34,491.51	-0.12%	\$33,236.18	3.66%	\$34,035.99	1.22%
S&P 500	\$4,392.59	\$4,480.52	-1.96%	\$4,205.79	4.44%	\$4,170.42	5.33%
Nasdaq	\$13,351.08	\$13,761.96	-2.99%	\$12,772.85	4.53%	\$14,038.76	-4.90%

Европийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
Dax	€ 14,163.85	€ 14,288.48	-0.87%	€ 13,689.02	3.47%	€ 15,209.15	-6.87%
FTSE 100	£7,616.38	£7,624.17	-0.10%	£7,196.00	5.84%	£6,939.60	9.75%

Азийн индекс	Одоо	7 хоногийн өмнөх	Өөрчлөлт	Сарын өмнөх	Өөрчлөлт	Жилийн өмнөх	Өөрчлөлт
CSI 300	¥4,188.75	¥4,155.93	0.79%	¥4,036.63	3.77%	¥4,948.97	-15.36%
Hang Seng	HKD 21,518.08	HKD 21,722.18	-0.94%	HKD 19,283.76	11.59%	HKD 28,900.83	-25.55%
Nikkei 225	JPY 27,093.19	JPY 26,811.77	1.05%	JPY 25,561.13	5.99%	JPY 29,642.69	-8.60%

Индексийн өөрчлөлт




Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ


### Дээд цэгтээ хүрсэн АНУ-ын инфляц хэзээ буцаад буурах вэ?

Өнгөрсөн 7 хоногт АНУ-ын хэрэглээний үнийн болон үйлдвэрлэлийн үнийн индекс зарлагдсан. Хэрэглээний үнийн индекс сүүлийн 40 жилийн хамгийн өндөр түвшинд хүрч, 12 сарын өмнөхтэй харьцуулахад 8.5%-иар өсөөд байна.



Хэрэв хүнс, эрчим хүчийг оруулахгүйгээр тооцвол 6.5%-иар өсжээ. Харин үйлдвэрлэлийн үнийн индекс сүүлийн 12 сард 11.2%-иар өссөн нь түүхэн дэх хамгийн өндөр үзүүлэлт юм.

Орос, Украины дайн үргэлжилж байхад түүхий эд болон эрчим хүчний үнийн өсөлтийн дарамт буурч байгаа нь инфляци удахгүй тогтворжих шинж тэмдэг юм. Тухайлбал, 3 сард West Texas Intermediate нефтийн дундаж үнэ 108 ам.доллар байсан бол 4 сард дунджаар 99 ам.доллар болсон. Хэрэв энэ хандлага үргэлжилбэл ойрын саруудад хэрэглээний үнийн индексийн инфляци буурна.




**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

АНУ-д хэрэглээний үнийн индексийн гуравны нэг орчим хувийг бүрдүүлдэг орон сууцны үнэ болон түрээсийн үнэ өссөн нь нийлүүлэлт бага байгаатай холбоотой. Ипотекийн зээлийн хүү өсөхийн хэрээр эрэлт буурч орон сууц болон түрээсийн үнэ унаж болох ч инфляцийн үзүүлэлтэд нөлөөлөхүйц болоход цаг хугацаа шаардагдана.

АНУ дахь 30 жилийн ипотекийн зээлийн хүү



Инфляцид нөлөөлдөг нэг хүчин зүйл нь хуучин болон шинэ автомашины үнэ юм. 3 сард үнэ буурсан нь ирэх саруудад, ялангуяа санхүүжилтийн хүү нэмэгдэж, эрэлт багасах үед илүү тогтвортой байдал руу шилжнэ.

Шинжээчдийн үзэж байгаагаар бол энэ жилийн сүүлийн хагаст инфляци тогтворжиж, буцаад буурах төлөв рүү шилжих болно. Энэ нь ганцхан түүхий эд гэлтгүй мөн нийт эрэлт, нийлүүлэлтийн тогтвортой байдал буюу хэрэглэгчийн эрэлт багасах, зах зээлд илүү их ажиллах хүч, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт эргэн ирэх зэрэгтэй шууд холбоо хамааралтай. Гэхдээ инфляц хэсэгтээ эргээд 2 хувьд хүрэхгүй. Учир нь түүхээс харахад инфляци 24-36 сарын хугацаанд дээд цэгээс доод цэг рүү шилждэг байна.

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.



## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### БНХАУ-д ковидын эсрэг тавьсан хөл хориог чангаллаа

БНХАУ-д ковидын нөхцөл байдал дордож байгаа учраас хөл хориог чангатгалаа.

Үндэсний Эрүүл Мэндийн Комиссоос Шанхайд 4 сарын 15-нд 24,791 шинэ тохиолдол бүртгэгдэж өмнөх өдрөөсөө 2.1 хувиар өссөн хэмээн мэдээлээд байна. Ингэснээр 4 сарын 15-ны байдлаар БНХАУ-д нийт 52,951 коронавирусын шинэ тохиолдол илэрчээ.

Тус хотын 25 сая оршин суугчдын дийлэнх нь хөл хорионд байгаа ба зөвхөн хүчинтэй үнэмлэхтэй, эрүүл мэндийн кодтой, COVID-ийн шинжилгээ сөрөг гарсан нь нотлогдсон ажилтнууд тусгай тээврийн хэрэгслээр бүсээс гарах боломжтой.

Шинэ хязгаарлалтууд нь нийлүүлэлтийн сүлжээний томоохон тасалдал үүсгэж байгаа нь Apple зэрэг компаниудын тээвэрлэлт саатахад хүргэж болзошгүй юм. Цахилгаан автомашины үйлдвэрлэгч Хpeng компаниас хэрэв Шанхай болон ойр орчмын бүс нутгийн ханган нийлүүлэгчид ажлаа хийж чадахгүй хөл хорионд хэвээр байх юм бол ирэх сард үйлдвэрлэлээ зогсооно гэв.

Эдийн засагчид энэ нь тус улсын эдийн засгийн өсөлтийн хурдад сөргөөр нөлөөлнө гэж үзэж байгаа тул хохирлыг багасгахын тулд банкнуудын нөөц болгон хадгалах ёстой бэлэн мөнгөний хэмжээг багасгажээ.



**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.

## Хувьцааны зах зээлийн онцлох мэдээ

### Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

E EARNINGS WHISPERS Most Anticipated Earnings Releases for the week beginning April 11, 2022									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
SIGMA LITHIUM	Argon	CARMAX	Albertsons	DELTA	BlackRock	tsmc	HEL BIZ	P3 Health Partners	
		ORGANIGRAM		RENT THE RUNWAY	Wafid Bank	WELLS FARGO			
				BED BATH & BEYOND		citi			
				FASTENAL		Morgan Stanley			
				Infosys		UNITEDHEALTH GROUP			
				First Republic Bank		RITE AID			
				THERA technologies		PNC			
				Shaw)		ally			
				SuperGroup		ERICSSON			
http://eps.sh/cal								© 2022 Earnings Whispers	

### Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

E EARNINGS WHISPERS The Most Anticipated Earnings Releases for the month beginning April 18, 2022 (only showing confirmed release dates)									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
18	CLIFFS	19	NETFLIX	20	ASML	21	Snap Inc.	22	CLIFFS
	AMERICAN EXPRESS		IBM		UNITED		AT&T		verizon
	synovus		TRUIST		Alkerm		AT&T		Scholarship
	LABORERS		Hydrex		Nasdaq		AT&T		SAP
									HCA
25	Coca-Cola	26	Microsoft	27	Meta	28	Apple	29	EgonMobile
	PHILIPS		VISA		Paycom		amazon		abbvie
	PACE		3M		Qualcomm		twitter		FLUOR
					celvovis		roku		FLUOR
02	onsemi	03	AMD	04	Uber	05	Block	06	DRIFT KINGS
	NXP		Ares		Magnite		shopify		FLUOR
	AGNC		MPX		Etsy		fubo		FLUOR
			teva		PORTNET		opendoor		FLUOR
09	Upstart	10	SoFi	11	CVS Health	12	coinbase	13	NYC
	DUKE ENERGY		unity		BARRETT		indie		NYC
	Clover		builders		RUSSIAN		compass		NYC
	GoodRx		ABSOLUTE		Paysafe		apix		NYC
16	consensus	17	Walmart	18	TARGET	19	Paycom	20	
	shade				CISCO		evolv		
					LOWE'S				
http://eps.sh/cal								© 2022 Earnings Whispers	

**Мэдэгдэл:** Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.